



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 10 сарын 29 өдөр

Дугаар 462

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга  
хэмжээний тухай

“Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан тухай хуулийн 48 дугаар зүйлийг зөрчиж 44,2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй худалдан авалт хийсэн, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4 дэх заалтыг зөрчиж 23,0 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний төлбөрийг бүрдэл дутуу баримтаар хийсэн, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг зөрчиж 25,9 сая төгрөгийн бараа, материалыг эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулалгүй авсан, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” тухай заалтыг зөрчиж компанид 45,9 сая төгрөгийн үргүй зардал гаргасан зэрэг нийт 166,4 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглэж, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Дараах арга хэмжээг авч, хэрэгжүүлсэн дүнг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт танилцуулахыг “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

2.1. “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2017-2018 оны удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, шалгалтын мөрөөр зохиох ажлын төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах;

2.2. Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдалд хяналт тавьж ажиллах үүргээ хангалтгүй биелүүлсэн “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн удирдах албан тушаалтанд хариуцлага тооцох;

3. “Булган-АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн захиралд дотоод хяналтыг сайжруулж, дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах;

3.2. Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

3.3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8-д заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэж, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

3.4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, санхүүгийн бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийдэг зөрчлийг арилгах;

3.5. Шатсан машины хохирол барагдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх, компанид шаардлагагүй сэлбэг хэрэгсэл, бараа, материал бэлтгэснээс учирсан үргүй зардлыг арилгах талаар хууль, хяналтын байгууллагатай хамтарч арилгах;

4. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа) - т даалгасугай.


ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын  
2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 462  
дугаар тогтоолын хавсралт



**Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг арилгах арга  
хэмжээний жагсаалт**

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	44,185.04	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах
2	Батлагдсан төлөвлөгөөнөөс гадуур болон хэтрүүлж авсан хөрөнгө	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	25,927.40	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах
3	Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төсвийн хууль, Мөнгөн кассын үйл ажиллагааны журам зөрчин бүрдэл дутуу баримтаар хийсэн ажил үйлчилгээ	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	23,045.70	Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
4	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг хэрэгслэл, бараа материал	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	27,285.20	Бараа материал бэлтгэх журам боловсруулж, мөрдөж ажиллах
5	Компанид шаардлагагүй сэлбэг, хэрэгслэл, бараа материал бэлтгэсэн	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	45,916.50	Шатсан машины хохирол барагдуулах тухай ТУЗ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, компанид учирсан хохиролыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 5-д заасны дагуу хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх,
	<b>Дүн</b>		<b>166,359.84</b>	

**БУЛГАН АЗЗА ТӨХК-ИЙН 2017-2018  
ОНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

2019 оны 09 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.4, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 66 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 12 дугаар тогтоолоор баталсан Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын хяналт шалгалт хийх төлөвлөгөөний дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын баталсан удирдамжаар “Булган-АЗЗА” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд тус хэлтсийн мэргэжилтэн, улсын ахлах байцаагч Н.Ган-Эрдэнэ, мэргэжилтэн Т.Анхбаяр нар 2019 оны 08 дугаар сарын 23-26-ны өдрүүдэд хийлээ.

Шалгалтад “Булган-АЗЗА” ТӨХК-ийн үйлдвэрлэлт борлуулалт, санхүү, техник эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн биелэлт, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, байгууллагын авлага, өглөгийн байдал, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон зохих журам, зааврын дагуу худалдан авалтыг төлөвлөн зохион байгуулж, тайлагнасан байдал, эд хөрөнгө, бараа материал, хандив тусламжийн зарцуулалт зэрэг асуудлуудыг хамруулж, холбогдох хууль тогтоомж болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгов.

Байгууллагын мөнгөн хөрөнгийн ажил гүйлгээг 2017-2018 онд ХААН банк, Хас банк гэсэн арилжааны 2 банкинд төгрөгийн 2 харилцах дансаар хийжээ.

Дээрх дансдын ажил гүйлгээнд нэгдүгээр гарын үсгийг 2018 оны 7 дугаар сарын 6 хүртэл Б.Батсайхан, 2018 оны 7 дугаар сарын 06-ны өдрөөс Б.Ууганбаяр нар, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Д.Амгалан нар зурж ирсэн байна.

**ХОЁР. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

“Булган-АЗЗА” ТӨХК нь Төрийн захиргааны байгууллагаас баталгаажуулсан улсын чанартай авто замын байгууламжийн засвар, арчлалтыг Зам, тээврийн хөгжлийн яамтай байгуулсан “Зам засвар, арчлалтын гэрээ”-ний дагуу Булган аймгийн хэмжээнд зохион байгуулж, түүгээр өнгөрч байгаа тээврийн хэрэгслэлийн хөдөлгөөнийг жилийн туршид саадгүй байлгах, зорчигчдын тав тухтай аялах нөхцөлийг хангаж ажиллах эрхэм зорилготой юм.

Энэхүү эрхэм зорилгын хүрээнд тус компани нь олон улсын чанартай Эрдэнэт-Булган /А-1002/ чиглэлд 24,1 км хатуу хучилттай зам, Булган-Мөрөн /А-0902/ чиглэлд 158,0 км хатуу хучилттай зам, Дашинчилэн-Булган /А-0901/ чиглэлд 38,95 км

сайжруулсан хайрган болон ердийн хөрсөн зам, Булган-Тэшиг-Улсын хил /А-13/ чиглэлд 136,6 км хайрган болон ердийн хөрсөн зам гэсэн 357,59 км авто замаас гадна Хануй, Орхон, Хялганат, Гурт, Эгийн 72,8-310,0 м-ийн урттай 5 ш бетонон гүүрийн засвар, арчлалтын ажлыг хариуцан гүйцэтгэж байна. Түүнчлэн өвөл цагийн зам арчлалтын ажлыг саадгүй хэвийн явуулах, зорчигчдын тав тухтай аялах нөхцөлийг хангах үүднээс Булган-Мөрөн чиглэлийн Төлүүгийн даваа, Эрдэнэт-Булган чиглэлийн Зоон даваа чиглэлийн замд байнгын ажиллагаатай шуурхай ажлын хэсгийн ажиллуулж байна.

“Булган-АЗЗА” ТӨХК нь нийт 2017-2018 онд нийт 71-83 ажиллагсадтай, БНХАУ, ОХУ, Япон улсын үйлчилгээний болон хүнд даацын автомашин, авто замын ажлын зориулалт бүхий 70 гаруй механизм, техник тоног төхөөрөмжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компани авто зам, замын байгууламжийг барих, засварлах, тусгай зөвшөөрлийг сунгаж, хайрган болон хатуу хучилттай зам барих, хатуу болон хайрган хучилттай зам засварлах, төмөр бетон, ган төмөр, модон гүүр засварлах, замын байгууламжид хамаарах талбай барих, засах, үерийн хамгаалалтын далан барих, бүх төрлийн гүүрийн засвар, замын тоноглол, тэмдэг, тэмдэглэгээний ажил хийх тусгай зөвшөөрлийн эрхийн дагуу үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөтгөн ажиллажээ.

Мөн олон улсын болон улсын чанартай замын бэлэн байдлыг хариуцан ажиллахын зэрэгцээ орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн засвар арчлалт, зам давааны засвар арчлалт, авто зам шинээр барих зэрэг орон нутгаас зарласан сонгон шалгаруулалтын ажлыг чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэсэн байна.

#### ГУРАВ: “БУЛГАН АЗЗА” ТӨХК-ИЙН 2017 ОН, 2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 284 дүгээр тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 608 дугаар тогтоолоор “Булган-АЗЗА” ТӨХК-ийн 2017, 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталжээ.

#### “БУЛГАН АЗЗА” ТӨХК-ИЙН 2017-2018 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНГИЙН БИЕЛЭЛТ

ä/ä	Үзүүлэлтүүд	/сая.төг/									
		2017 он		Харьцуулалт		2018 он		Харьцуулалт			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тоо	Хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөөнөөс		өмнөх оноос	
						тоо	хувь	тоо	хувь		
1	<b>Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт</b>	1,285.3	1,384.3	99.0	7.7	1,850.2	1,759.9	(90.3)	-4.9	375.6	27.1
	Улсын чанартай ЗЗА-ын ажил	510.3	1,049.4	539.1	105.6	1,488.6	1,169.9	(318.7)	-21.4	120.5	11.5
	Орон нутгийн чанартай ЗЗА	775.0	334.9	(440.1)	-56.8	361.6	590.0	228.4	63.2	255.1	76.2
2	<b>Нийт орлого</b>	1,285.3	1,384.3	99.0	7.7	1,850.2	1,780.0	(70.2)	-3.8	395.7	28.6
3	<b>Нийт зардал</b>	1,278.8	1,379.2	100.4	7.9	1,832.9	2,345.8	512.9	28.0	966.6	70.1
	Үүнээс: Удирдлагын зардал	254.8	284.2	29.4	11.5	361.1	336.8	(24.3)	-6.7	52.6	18.5
4	<b>Татварын өмнөх ашиг</b>	6.5	5.1	(1.4)	-21.5	17.3	(585.9)	(603.2)		-591.0	
5	Цэвэр ашиг/ алдагдал/	5.8	4.6	(1.2)	-20.7	15.5	(585.9)	(601.4)		-590.5	
6	<b>Төсвийн төлбөр</b>	115.0	224.7	109.7	95.4	180.4	369.8	189.4	105.0	145.1	64.6
7	Нийт ажиллагсдын тоо	71	71	-	0	83	65	(18)	-21.7	-6	-8.5

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

8	Нийт цалингийн сан	384.3	340.5	(43.8)	-11.4	609.4	497.8	(111.6)	-18.3	157.3	46.2
9	Нэг ажиллагчийн дундаж цалин	0.5	0.4	(0.1)	-11.1	0.6	0.6	0.0	6.7	0.2	60.0
10	Бор.лтын нэг төгрөгт ногдох зард	1.0	1.0	-	0.0	1.0	1.3	0.3	34.2	0.3	34.2
11	Нийт авлага	50.1	238.6	188.5	376.2	97.2	133.2	36.0	37.0	-105.4	-44.2
12	Нийт өглөг	600.6	1,030.8	430.2	71.6	607.3	849.7	242.4	39.9	-181.1	-17.6
	Үүнээс: Богино хугацаат өглөг	35.4	465.6	430.2	1215.3	42.1	284.5	242.4	575.8	-181.1	-38.9
13	Хөрөнгө оруулалт	130.0	139.0	9.0	6.9	236.8	565.2	328.4	138.7	426.2	306.6

**Нийт орлого:** “Булган-А33А” ТӨХК 2017 онд 1,285.3 сая төгрөгийн орлоготой ажиллахаас 1,384.3 сая төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 99,0 сая төгрөг буюу 7,7 хувиар давуулан биелүүлжээ. 2017 оны зуны үер усны гамшгийн улмаас Булган-Мөрөн чиглэлийн замд эвдрэл гарч, 127,5 сая төгрөгийн онцгой ажил, үүрэг гүйцэтгэсэн, ЗТХЯ-ны тодотголоор 537,5 сая төгрөгийн зам засварын нэмэлт ажил хийгдсэн нь орлогын төлөвлөгөө давж биелэхэд нөлөөлсөн байна.

2018 онд компани 1,780.0 сая төгрөгийн орлого олж, батлагдсан төлөвлөгөөг 70,2 сая төгрөг буюу 3,8 хувиар тасалсан байна. Тайлант онд орон нутгийн чанартай зам засвар, арчлалтын ажлыг 228,4 сая төгрөг буюу 63,2 хувиар давуулж, улсын чанартай зам засвар, арчлалтын ажлын төлөвлөгөөг 318,7 сая төгрөг буюу 21,4 хувиар тасалсан байна.

**Нийт зардал:** “Булган-А33А” ТӨХК 2017 онд батлагдсан зардлыг 100,4 сая төгрөг буюу 7,9 хувиар хэтрүүлсэн байна. Үер усны гамшгийн нөхцөл байдалтай уялдан онцгой нөхцөлөөр зам засвар, арчлалтын нэмэлт ажил хийгдсэн нь зардал хэтрэхэд голлон нөлөөлжээ.

Компани 2018 онд 1,832.9 сая төгрөгийн зардалтай ажиллахаас 2,345.8 сая төгрөгийн зардал гаргаж, батлагдсан төлөвлөгөөг 512,9 сая төгрөг буюу 28,0 хувиар хэтрүүлжээ. 2018 орлогын орлогын төлөвлөгөөг 70,2 сая төгрөгөөр тасалсан боловч өртөг зардлыг хямдруулан боломжит зардлыг бууруулж ажиллахын оронд зардлыг ийнхүү хагас тэрбум төгрөгөөр хэтрүүлж ажиллажээ. 2018 оны үйлдвэрлэлийн зардлын гүйцэтгэлээс харахад материал түүхий эдийн зардлыг 158,3 сая, шатахууны зардлыг 58,4 сая сэлбэг хэрэгслэлийн зардлыг 66,2 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 319,8 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна. Компани байдал ийм байхад үндсэн үйлдвэрлэл, өртөг зардлын гүйцэтгэлийг урьдчилан тооцож, компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд өөрчлөлт оруулах саналыг ТУЗ-аар хэлэлцүүлэн, эрх бүхий байгууллагын тогтоол шийдвэр гаргаж ажиллаагүй байна.

“Булган-А33А” ТӨХК-ийн 2017-2018 оны  
үйлдвэрлэлийн зардлын гүйцэтгэл

		2017 он				2018 он				/сая төгрөг/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт		
				тоо	хувь			тоо	хувь	
1	Материал, түүхий эд	236.0	271.4	35.4	15.0	300.9	459.2	158.3	52.6	
2	Шатахуун	146.1	153.6	7.5	5.1	190.2	248.6	58.4	30.7	

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

3	Сэлбэг, хэрэгслэл,	60.3	63.1	2.9	4.8	60.3	126.5	66.2	109.9
4	Тоног, төхөөрөмж	2.6	2.8	0.2	6.1	2.6	-	(2.6)	-100.0
5	Дулаан	6.4	0.1	(6.3)	-97.9	3.8	0.2	(3.6)	-94.9
6	Цахилгаан	5.8	2.9	(2.9)	-50.3	1.6	2.8	1.3	79.9
7	Тээвэр	1.2	5.4	4.2	347.3	1.2	-	(1.2)	-100.0
8	Хөдөлмөр хамгаалал	9.9	8.5	(1.3)	-13.5	21.6	21.1	(0.5)	-2.1
9	Томилолт	5.7	2.6	(3.1)	-55.0	7.0	7.9	0.9	13.4
10	Хээрийн нэмэгдэл	35.2	47.4	12.2	34.5	35.9	61.5	25.7	71.6
11	Бичиг хэргийн зардал	1.5	1.5	(0.0)	-1.9	1.5	0.2	(1.3)	-89.6
12	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	-	-	-	-	-	319.8	319.8	
13	Түрээс	10.4	17.2	6.8	65.9	31.1	77.7	46.7	150.1
14	Газар, байгалийн нөөцийн	5.0	19.6	14.6	292.3	5.0	9.5	4.5	89.2
15	Түлээ нүүрсний хөнгөлөлт	3.4	-	(3.4)		11.4	9.8	(1.6)	-13.7
16	Бусад зардал	-	19.6	19.6		5.0	25.9	20.9	417.4
17	Даатгалын зардал	15.7	15.7	0.1	0.4	8.5	13.7	5.2	61.4
	<b>Материаллаг зардлын дүн</b>	<b>547.1</b>	<b>631.5</b>	<b>84.3</b>	<b>15.4</b>	<b>690.4</b>	<b>1,364.5</b>	<b>697.1</b>	<b>101.4</b>
1	Үндсэн хөрөнгийн элэгдэл	171.3	182.6	11.3	6.6	255.5	210.9	(44.6)	-17.5
2	Үндсэн ба нэмэгдэл цалин	270.4	248.6	(21.9)	-8.1	465.4	381.0	(84.4)	-18.1
3	Нийгмийн даатгалын шимтгэл	35.2	32.3	(2.9)	-8.1	60.5	52.7	(7.8)	-12.9
	<b>Материаллаг бус зардлын дүн</b>	<b>476.9</b>	<b>463.5</b>	<b>(13.4)</b>	<b>-2.8</b>	<b>781.4</b>	<b>644.6</b>	<b>(136.8)</b>	<b>-17.5</b>
	<b>Нийт дүн</b>	<b>1,024.1</b>	<b>1,095.0</b>	<b>70.9</b>	<b>6.9</b>	<b>1,471.8</b>	<b>2,009.0</b>	<b>560.2</b>	<b>38.1</b>

Тайлбар: /Удирдлагын зардлыг хассан дүнгээр/

Булган-А33А ТӨХК-ийн 2017 он, 2018 оны авлага

мян.төг

д/д	Авлага	2017 он		Өөрчлөлт		2018 он		Өөрчлөлт	
		эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Тоо	Хувь	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Тоо	Хувь
1	Байгууллага	41,194.3	44,702.9	3,508.5	8.5	44,702.9	21,998.2	- 22,704.6	(50.8)
2	Ажилчид	8,472.3	10,880.3	2,408.0	28.4	10,880.3	6,807.1	- 4,073.2	(37.4)
3	Иргэн	27,790.3	63,210.4	35,420.1	127.5	63,210.4	68,519.5	5,309.1	8.4
4	Урьдчилгаа авлага	1,766.8	2,032.3	265.5	15.0	2,032.3	2,173.5	141.2	6.9
5	ОНЗсанаас авах	107,531.9	105,614.5	-1,917.4	(1.8)	105,614.5	23,508.1	- 82,106.4	(77.7)
6	Бригад тооцоо	2,910.5	5,180.5	2,270.0	78.0	5,180.5	4,753.0	-427.5	(8.3)
7	Жолооч нараас авах	3,454.0	6,715.5	3,261.5	94.4	6,715.5	5,433.2	-1,282.3	(19.1)
	<b>Дүн</b>	<b>193,120.2</b>	<b>238,336.3</b>	<b>45,216.1</b>	<b>23.4</b>	<b>238,336.3</b>	<b>133,192.6</b>	<b>-105,143.7</b>	<b>(44.1)</b>

Булган-А33А ТӨХК 2017 онд санхүүгийн тайлангаар 238,3 сая төгрөгийн авлагатай гарч оны эхний авлагыг 45,2 сая төгрөг буюу 23,4 хувиар нэмэгдүүлсэн байна. Гүйцэтгэлийг зорилтот түвшингийн үзүүлэлттэй харьцуулахад 188,5 сая төгрөгөөр нэмэгдсэн дүнтэй байна. Нийт авлагын 44,3 хувийг орон нутгийн замын сангаас авах авлага, 29,3 хувийг хүмүүс болон жолооч нараас авах авлага, 18,8 хувийн байгууллагаас авах авлага эзэлж байна.

Компани 2018 онд санхүүгийн тайлангаар 133,2 сая төгрөгийн авлагатай ажиллаж, оны эхний авлагыг 105,1 сая төгрөг буюу 44,1 хувиар бууруулж ажилласан байна. Авлагын гүйцэтгэлээс үзэхэд 2018 онд ОНЗС-аас авах авлагыг 82,1 сая төгрөг буюу 77,7 хувь байгууллагаас авах авлагыг 22,7 сая төгрөг буюу 50,8 хувиар бууруулсан нь нийт авлага буурахад голлон нөлөөлжээ. Авлага нийт дүнгээр 108 сая төгрөгөөр буурч, 133,2 сая төгрөг болсон хэдий ч зорилтот түвшингийн үзүүлэлтийг 36,0 сая төгрөг буюу 37 хувиар тасалсан байна.

## Булган-АЗЗА ТӨХК-ийн 2017 он, 2018 оны өглөг

д/д	дансны нэр	2017 он		Өөрчлөлт		2018 он		Өөрчлөлт	
		эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Тоо	Хувь	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Тоо	Хувь
1	Байгууллага	64,147.2	67,199.6	3,052.4	4.8	67,199.6	43,570.8	(23,628.8)	(35.2)
2	Ажилчид	(360.4)	5,296.5	5,656.9	(1,569.7)	5,296.5	2,299.2	(2,997.2)	(56.6)
3	Хүмүүст	11,345.8	37,387.4	26,041.6	229.5	37,387.4	2,071.0	(35,316.4)	94.5)
4	НӨАТ өглөг	86,055.7	122,626.9	36,571.2	42.5	122,626.9	151,939.5	29,312.6	23.9
5	ХАОАТ өглөг	15,022.1	20,379.6	5,357.5	35.7	20,379.6	22,469.4	2,089.7	10.3
6	Суутган	-	7,985.0	7,985.0		7,985.0	7,994.6	9.6	0.1
7	ААНОАТ	3,734.1	4,247.3	513.1	13.7	4,247.3	3,739.1	(508.1)	12.0)
8	Шугамын зээл	-	199,999.3	199,999.3		199,999.3	49,999.3	150,000.0)	(75.0)
9	Урт хугацаат зээл	565,211.3	565,211.3	-	-	565,211.3	65,211.3	-	-
	<b>Дүн</b>	<b>745,155.9</b>	<b>1,030,332.9</b>	<b>285,177.0</b>	<b>38.3</b>	<b>1,030,332.9</b>	<b>849,294.2</b>	<b>(181,038.7)</b>	<b>(17.6)</b>

Булган-АЗЗА ТӨХК 2017 онд санхүүгийн тайлангаар 1,030.3 сая төгрөгийн өглөлтэй ажиллаж оны эхний өглөгийг 285,2 сая төгрөг буюу 38,3 хувиар нэмэгдүүлсэн байна. Өглөг нэмэгдэхэд 2017 онд 200,0 сая төгрөгийн богино хугацаатай зээл авсан, НӨАТ-ын өглөг 36,6 сая төгрөгөөр нэмэгдсэн, хүмүүст өгөх өглөг 26,0 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. 2017 онд өглөгийн талаар зорилтот түвшинд тусгагдсан үзүүлэлтийг хангаж ажиллаагүй байна.

Компани 2018 онд 849,3 сая төгрөгийн өглөгтэй ажиллаж оны эхний өглөгийг 181,0 сая төгрөг буюу 17,6 хувиар бууруулж ажилласан байна. Банкнаас авсан богино хугацаат зээлийг 150 сая төгрөг, хүмүүст өгөх өглөгийн 35,3 сая төгрөгөөр бууруулсан нь голлон нөлөөлжээ.

#### 4. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

“Булган-АЗЗА” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт **166,359.84** мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Үүнд:

**4.1. Зорилтот түвшинд тусгагдсан хөрөнгө оруулалтын зардлыг хэтрүүлсэн:** “Булган-АЗЗА” ТӨХК нь ТӨБЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 284, 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 608 дугаар тогтоолоор “Булган-АЗЗА” ТӨХК-ийн 2017, 2018 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан бөгөөд энэ хугацаанд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийгдээгүй байна.

Компани дээрх хугацаанд зорилтот түвшинд батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2017 онд 20,875.3 мянган төгрөг, 2018 онд 5,052.1 мянган төгрөг бүгд 25,927.4 мянган төгрөгөөр тус тус хэтрүүлсэн байна.  
**25,927.4** мянган төгрөгөөр хэтрүүлсэн байна.

“Булган-АЗЗА” ТӨХК-аас 2017 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур худалдан авсан үндсэн хөрөнгө

/мянган төгрөг/

№	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтэрсэн
1	Автогрейдер	80,000.0	80,000.0	-
2	Индүү	50,000.0	60,000.0	10,000.0
3	Буйдан /хар/		2,315.0	2,315.0
4	Захирал ширээ		1,600.0	1,600.0
5	Телевизор		3,271.8	3,271.8
6	Дарга сандал		310.3	310.3
7	Дарга түмбочка		378.2	378.2
8	Модон сандал		600.0	600.0
9	Нотөбүүк		1,500.0	1,500.0
10	Хар сандал/801/		190.0	190.0
11	Хурлын ширээ		710.0	710.0
	<b>Дүн</b>	<b>130,000.0</b>	<b>150,875.3</b>	<b>20,875.3</b>

“Булган-АЗЗА” ТӨХК-аас 2018 онд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс гадуур худалдан авсан үндсэн хөрөнгө

/мянган төгрөг/				
№	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтэрсэн
1	Зөөврийн компьютер		3,800.00	3,800.0
2	Хэвлэгч		325.00	325.0
3	Сандал		545.40	545.4
4	Сейф		381.70	381.7
	<b>Дүн</b>		<b>5,052.10</b>	<b>5,052.1</b>

**4.2.** “Булган-АЗЗА” ТӨХК нь 2017-2018 онд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж, гүйцэтгэлийг тайлагналгүй явж иржээ.

Компани 2017-2018 онд нийт **44,185.04** мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, батлуулаагүй байна.

Он	№	Бараа, ажил, үйлчилгээ	Зардлын дүн /мян.төг/
2017	1	Будаг	17,920.0
		<b>Дүн</b>	<b>17,920.0</b>
2018	1	Цемент	14,990.0
	2	Хөдөлмөр хамгааллын хувцас	11,275.0
		<b>Дүн</b>	<b>26,265.0</b>
<b>Нийт дүн</b>			<b>44,185.0</b>

**4.3. Захиалгын хуудасгүй бэлтгэсэн бараа материал:** Аливаа байгууллагын хангамж, худалдан авалт хариуцсан ажилтан нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу холбогдох албадаас ирүүлсэн шаардлагатай бараа материал, сэлбэг хэрэгслэлийн нэр төрөл, тоо хэмжээний захиалгыг сар бүр авч нэгтгэн зах зээлээс бэлтгэн нийлүүлэх боломжийг судлан зайлшгүй бэлэн мөнгөөр худалдан авах,

олдоц багатай бараа материалын судалгааг гарган удирдлагад танилцуулж, худалдан авах тоо хэмжээ, зах зээлээс нийлүүлэх үнийн талаар тохирч, хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэн батлуулж ажиллах зарчимтай.

Гэтэл “Булган-АЗЗА” ТӨХК нь энэ журмыг зөрчиж 2016 он, 2017 онд байгууллагад шаардлагатай эсэх нь тодорхойгүй **27,285.2** мянган төгрөгийн сэлбэг хэрэгслэл, бараа материалыг захиалгын хуудасгүйгээр албан тушаалтнуудын дараа тайлангаар мөнгө олгох хүсэлтийн дагуу олгож бэлтгүүлжээ.

2017 онд захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг, бараа материал

/мян.төг/			
Огноо	Гүйлгээний утга	Харилцагч	Дүн
1/3/2017	Сэлбэг	Оюун.Ш	2,600.0
2/17/2017	Барилгын материал	Хараа сүмбэр ХХК	2,018.4
5/31/2017	жоби будаг	Нигүүлсэн зам ХХК	2,000.0
5/24/2017	Материал, сэлбэг	Мөнх-Эрдэнэ.Э	1,000.0
8/19/2017	Материал	Нямжаргал.Б	1,011.8
	<b>Дүн</b>		<b>8,630.2</b>

2018 онд захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг, бараа материал

/мян.төг/			
Огноо	Гүйлгээний утга	Харилцагч	Зардал
3/6/2018	Прадо мотор	Авто mall	3,100.0
10/11/2018	Дугуй	Батболд.Ч /дугуй/	1,615.0
10/11/2018	Дугуй	Найман талт уул ХХК	3,700.0
10/12/2018	Сэлбэг	Мөнх-Эрдэнэ.Э	6,000.0
11/14/2018	Хар фанер	Баясгалант бүрд хоршоо	3,040.0
12/22/2018	Мотор	Мөнх-Эрдэнэ.Э	1,200.0
	<b>Дүн</b>		<b>18,655.0</b>

**4.4. Бүрдэл дутуу баримтаар хийсэн гүйлгээ:** “Булган-АЗЗА” ТӨХК-ийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 2017-2018 оны касс, харилцахын баримт шалгахад нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” тухай заалтыг зөрчиж хавсралтад заасан **23,045.7** мянган төгрөгийн арга хэмжээг бүрдэл дутуу баримтаар санхүүжүүлсэн байна.

Бүрдэл дутуу баримтаар хийсэн гүйлгээ-2017 он

Огноо	Гүйлгээний утга	Харилцагч	Зардал /мян.төг/	Тайлбар
1/23/2017	Материал	Хул шанд трейд ХХК	1,338.8	Баримтын бүрдэл дутуу
2/10/2017	Арматур төмөр	Төмөр тууз ХХК	1,067.0	Баримтын бүрдэл дутуу
3/7/2017	Грейдрийн хутга	Түмэн төмөрт ХХК	759.3	Үндсэн баримтгүй
5/5/2017	Цемент	Бат-Эрдэнэ.А	2,835.0	Үндсэн баримтгүй

4/21/2017	Хүнсний материал	Нямжаргал.Б	1,300.0	Баримтын бүрдэл дутуу
12/8/2017	Прадо 27-01 БУЛ Сэлбэг	Батжаргал.Ц	2,134.8	Баримтын бүрдэл дутуу
	Дүн		9,434.9	

#### Бүрдэл дутуу баримтаар хийсэн гүйлгээ-2018 он

Огноо	Гүйлгээний утга	Харилцагч	Зардал /мян.төг/	
4/20/2018	Төвийн бүсийн уралдаан тэмцээн	Батжаргал.Ц	753.0	Тушаалгүй
12/7/2018	Хойд бүсийн АЗЗА компаниудын спортын арга хэмжээ	Цэнгэлмаа.Д	6,912.6	Тушаалгүй
12/18/2018	Тэмцээний хоолны төлбөр	Булган Анар ХХК	4,303.6	Тушаалгүй
12/28/2018	Шинэ жилийн арга хэмжээ	Ундармаа.Б	1,641.6	Тушаалгүй
	Дүн		13,610.80	

**4.5. Үргүй зардал:** Булган-АЗЗА ТӨХК-ийн захирал Б.Ууганбаяр 2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд Булган аймгийн Хишиг-Өндөр, Бүрэгхангай сумдад ямар ч гэрээ хэлэлцээргүй ажилд Засаг даргын хүсэлтээр компанийн 11-76 БУЛ улсын дугаартай өөрөө буулгагч машиныг ажиллуулахаар ерөнхий инженер Э.Мөнх-Эрдэнэд үүрэг өгч, жолооч Д.Энхээ, механизмчин Б.Эрдэнэбат нарыг томилж явуулсан байна. Гэвч жолооч нар ажлын хариуцлага алдан согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ техник хэрэгслэлийг жолоодож, улмаар дамжуулагч утсанд богино холболт үүссэний улмаас машин шатаж, даатгалын компанийн үнэлгээгээр компанид 10,019.0 мянган төгрөгийн хохирол учруулсан байна.

Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, компанийн ТУЗ-ийн хамтарсан ажлын хэсгээс хийсэн шалгалтаар гэрээ, хэлэлцээргүй ажилд компанийн машин механизмыг дайчилсан захирал Б.Ууганбаярын буруутай үйл ажиллагаанаас машин шатаж, компанид хохирол учирсан гэж дүгнэсэн байна. Улмаар Компанийн ТУЗ-ийн 2019 оны “Зөрчил арилгуулах тухай” 05 дугаар тогтоолоор хариуцлага алдан компанид хохирол учруулсан захирал Б.Ууганбаярыг өөрийн хөрөнгөөр төлүүлэх үүрэг болгосон байна.

Гэвч захирал Б.Ууганбаяр, ерөнхий инженер Э.Мөнх-Эрдэнэ нар уг машины сэлбэг болон бусад бараа материалыг худалдан авахаар **45,916.5** мянган төгрөгийг өөрийн хувийн дансаар дамжуулан авч БНХАУ-ын Эрээн хотоос батлагдсан захиалгын хуудасгүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй сэлбэг хэрэгслэл, бараа материалыг бэлтгэн авчирсныг өнөөдрийг хүртэл орлогод аваагүй, агуулахад хадгалагдаж, үргүй зардал гарсан байна.

№	Огноо	Банк	Дансны дугаар	Харилцагч	Бараа материалын нэр	Зардлын дүн
1	2019.04.05	Хаан банк	5270400683	Э.Мөнх-Эрдэнэ	Сэлбэгийн урьдчилгаа	30,000.00
2	2019.04.11	Хас банк	5001005145	Д.Бурмаа	Сэлбэгийн урьдчилгаа	3,930.00
3	2019.04.13	Хаан банк	5270400683	Э.Мөнх-Эрдэнэ	Сэлбэг	11,986.50
				Дүн		45,916.50

## 5. САНАЛ ДҮГНЭЛТ, ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

“Булган-АЗЗА” ТӨХК 2017 онд 1,384.3 сая төгрөгийн орлого олж, 1,379.2 сая төгрөгийн зардал 5,1 сая төгрөгийн ашигтай ажилласан бол 2018 онд 1,780.0 сая төгрөгийн орлого олж, 2.345.8 сая төгрөгийн зардал гарган 585.8 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

“Булган-АЗЗА” ТӨХК-ийн 2017 он, 2018 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль зөрчиж **166.4** сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрлээ.

Цаашид компанийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үргүй зардлыг арилгах, хөрөнгийн өгөөжийг сайжруулах, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг бодитоор хийх, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль, журмын дагуу төлөвлөх, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, төлөвлөгөөний тодотгол хийх ажилд онцгой анхаарч, санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн дээрх зөрчил дутагдлыг арилгах асуудлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

1. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль, Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8-д заасны дагуу үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг шинээр худалдан авахдаа төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэрийг үндэслэж, зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авахгүй байх;

3. Мөнгөн кассын үйл ажиллагаанд Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар батлагдсан мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах, бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил, үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрөөс бусад тохиолдолд мөнгөн гүйлгээг бэлэн мөнгөөр гүйцэтгэх явдлыг зогсоох;

4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтыг хэрэгжүүлж, санхүүгийн бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийдэг зөрчлийг арилгах;

5. “Төсвийн тухай хууль”-ийн 6.4.1-д заасан “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” тухай заалтыг мөрдөж, шатсан машины хохирол барагдуулах тухай ТУЗ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, компанид шаардлагагүй сэлбэг хэрэгслэл, бараа, материал бэлтгэснээс учирсан үргүй зардлыг арилгах талаар хууль, хяналтын байгууллагатай хамтарч арилгах,

Танилцсан:

А.Дагвадорж  
/Дэд дарга/

Хянасан:

*Ц.Түвшинзаяа*  
2009.10.21  
*Ө.Батбаатар*

Ц.Түвшинзаяа  
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын  
хэлтсийн дарга, Улсын ахлах байцаагч/

Ө.Батбаатар  
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтсийн ахлах  
мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч/

Тайлан  
боловсруулсан:

*Н.Ган-Эрдэнэ*

Н.Ган-Эрдэнэ  
/Төрийн өмчийн бүртгэл, хяналтын  
хэлтсийн мэргэжилтэн, Улсын ахлах байцаагч/

Зөвшөөрсөн:



Б.Батсайхан /"Булган-АЗЗА" ТӨХК-н захирал/

Г.Цэцэгмаа /Ерөнхий нягтлан бодогч/

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээний худалдан авалт	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	44,185.04	Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах
2	Батлагдсан төлөвлөгөөнөөс гадуур болон хэтрүүлж авсан хөрөнгө	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	25,927.40	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах
3	Нягтлан бодох бүртгэлийн хууль, Төсвийн хууль, Мөнгөн кассын үйл ажиллагааны журам зөрчин бүрдэл дутуу баримтаар хийсэн ажил үйлчилгээ	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	23,045.70	Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.1.4-д заасан "Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх" заалтыг мөрдөж ажиллах
4	Захиалгын хуудасгүй бэлтгэсэн сэлбэг хэрэгслэл, бараа материал	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	27,285.20	Бараа материал бэлтгэх журам боловсруулж, мөрдөж ажиллах
5	Компанид шаардлагагүй сэлбэг, хэрэгслэл, бараа материал бэлтгэсэн	Захирал Б.Батсайхан Ерөнхий ня-бо Г.Цэцэгмаа	45,916.50	Шатсан машины хохирол барагдуулах тухай ТУЗ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, компанид учирсан үргүй зардлыг арилгах асуудлыг хууль, хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэх,
	<b>Дүн</b>		<b>166,359.84</b>	